

**ЭЛЧИН САЙД НАРЫГ ЭГҮҮЛЭН ТАТАХ, ТОМИЛОХ АСУУДЛААР ЗӨВШИЛЦӨХ
ТУХАЙ САНАЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зөвшилцөхөөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зөвшилцөхөөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хамтатган хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Элчин сайдаар ажилласан хугацааны тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулж, тайлагнадаг байх, төрийн болон хувийн хэвшилд ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, гадаадад сургахад анхаарах, иргэн, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн болон хөдөө, аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Элчин сайдад нэр дэвшигчдийг дэмжиж байгаа бөгөөд зарим нэр дэвшигчээс суугаа орны хамтын ажиллагааны хүрээнд санал, санаачилгатай ажиллахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Монгол Улсын өрсөлдөх чадварыг олон улсад таниулах, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, суугаа улсын шинэ технологийг нэвтрүүлэх, боловсролын салбарын шинэчлэл хийх, туршлага судлахад анхаарч ажиллах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр гадаад харилцааны салбарт олон жил ажилласан, мэргэжлийн, туршлагатай нэр дэвшигчид байгаад талархаж байгаагаа илэрхийлээд, олон улсын харилцаа, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх, суугаа улсад ажиллаж, амьдарч байгаа иргэддээ ойр байх, иргэд, хувийн хэвслээ дэмжих, зах зээлээ тэлэх, тухайн улсынхаа сайн жишээг хуваалцах, мэдээлэл солилцох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт орон тоо нэмэгдэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн гадаад харилцааны салбар ажлаа хариуцлагатай гүйцэтгэж байгаа талаар дурдаад, нэр дэвшигчид дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөх, зээл, тусламжийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцаагаа сайжруулахад анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн

Н.Батсүмбэрэл дипломат албанд ажилласан дадлага, туршлагатай, мэргэжлийн нэр дэвшигч нар томилогдож байгааг дэмжиж, нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Элчин сайд нарыг эгүүлэн татах саналаар санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Түүнчлэн Элчин сайд нарыг томилох асуудлаар нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Д.ЭНХТҮВШИН